

Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ийн онцлог

Гэрэлтийн Саруул

(Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургууль, Өвөр Монгол Хөх хот 010010)

Агуулгийн товч: Ли Ши Шиан нь Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн профессор, алдарт хөгжимийн зохиолч юм. Хөгжимийн зохиолч Ли Ши Шиан 1998-2001 онуудад бициж туурвисан “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” гэх төгөлдөр хуурт зориулсан цуврал байна. Тэр нь монгол ардын аялгуунаас сэдэвлэн төгөлдөр хуурт зориулсан 10 бүлэгт 47 цуврал болох юм. Бүтээлүүдийн онцлог нь хятадын уламжлалт болон орчин үеийн хөгжмийн хэв шинжийг агуулахаас гадна өрнө дахины төгөлдөр хуурын зохиомжид түшиглэн боловсруулсанаар Өвөр монголчуудын ардын дууны өнгө тембр, хөг намба, фактур, уртын дууны дуулах онцлогийг төгөлдөр хуурт чадамгай илэрхийлсэн байна.

Зангилгийн үг: Ли Ши Шиан; Төгөлдөр хуурын цуврал бүтээл; онцлог

Ли Ши Шиан нь 1957 онд Өвөр Монголын Зүүн хэсгийн Хорчин тал нутгийн хойд хэсгийн Сүхтэй тосгонд мэндэлжээ. Бага наснаасаа сэхээрүүлэгч багш Яу Жан Лайн удирдлага дор дуу хөгжим суралцаж эхэлжээ. Тэрээр 1975 оноос эхлэн “Улаан мөчир” дуу хөгжмийн бүлгэмийн уран сайхын ажилд оролцож хуучир, хийл хөгжмөөр хөгжимдөж байжээ. Үүний зэрэгцээ хөгжмийн зохиолч Do Zhao Zhi-û удирдлага доор дууны ая зохиож уран бүтээлийн гараагаа эхэлжээ. 1989 онд Шанхайн Дуу хөгжмийн дээд сургуулийг хөгжмийн удирдаачийн мэргэжлээр дөтөгсжээ. Ли Ши Шиан нь Жан Ду Жи, Ян Ли Чин, Лин Хуа зэрэг профессоруудаас хөгжмийн онол болон хөгжмийн зохиомжийн мэргэжлийг эзэмшсэн байна. Одоо Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуульд хөгжмийн факультетын эрхлэгчээр ажиллаж байна.

Дундад улсын хөгжмийн зохиолчийн өсөн бойжилт цаашлан хөгжим зохиох чадварыг хүмүүжүүлэх талаар өрнө дахинтай харьцуулбал нэн хэцүү юм. Шао Юу Мэй гуайгаар XX зууны эхнээс дуу хөгжмийн заан сургалтыг эхлүүлсэнээр дундад улсын хөгжмийн зохиолчдоос олонхидоо биедээ давхар үүрэг үүрүүлж зохион бүтээхийн хамт заан сургах ажлыг эрхэлдэг нь үнэхээр сонин хэрэг биш ажээ. Өрнө дахины дуу хөгжмийн онол хийгээд хөгжим зохиох арга мэргэжил (Эртнээс эдүгээг хүртэлх)-ийг сайн сурах мөртөө бас дундад улсын уламжлалт дуу хөгжим (Ордоны хөгжмөөс ардын хөгжим хүртэлх)-ийг сайн суръя гэвэл бодитой зохион бүтээх явцдаа тасралтгүй эрж хайх хэрэгтэй. Энэхүү эрэлт хайлт нь хичнээн бэрх ажээ. Үүнийг дундад улсын хөгжмийн зохиолчийн хувь заяа гэж хэлж болмоор. Мөн ч туйлын шилдэг уламжлал гэж хэлж болно. Энэхүү уламжлал нь үеийн үед залгамжлагдаж, Ли Ши Шиан ч энэхүү харгуйгаар уран бүтээлийнхээ гарааг тавьсан билээ.

Түүний бүтээлүүдээс дурдвал: “Монгол үндэстний уртын дууны онол”, “Дуу хөгжмийг хавсран хөгжимдөх, зохион бүтээх арга мэргэжил”, “Дөрвөн утаст хуур найрал хөгжимд зориулсан “Үлгэр ярих” найраглал, “Тал нутагтаа өргөнөм”, дан найрал дуунд зориулсан “Гаадаа Мээрэний дуу”, “Сүүтэй цайны хайр”, “Чамайг дагана” бүжгийн хөгжийм “Бяцхан малчин”, “Тэнгэрийн шулмасын бүжиг” зэрэг орно. Түүний маш олон бүтээл улсын болон Өөртөө засах орны шагналуудыг хүртэж байв. Мөн тайз дэлгэцийн бүтээлүүд нь нэлээд дэлгэрч олны анхаалыг зүй ёсоор татаж байгаа билээ.

Түүний уран бүтээлийг үнэлж Өвөр Монголын Өөртөө Засах Орны “Сарнай” (Засгийнгазраас шилдэг уран бүтээлчид олгодог) шагналыг 2 удаа олгосон байна.

Дэлхийн аль ч газар орны үндэстний дуу хөгжмийн хөгжлийг ерөнхийлэн ажиглахад ихэнх нь тус орныхоо үндэстний дуу хөгжмөөс урган гарсан бөгөөд хөгжим эхлэн суралцагсад нь үндэстний дуу хөгжмөөр ундаалахын ашиг тусыг хүртдэг.

Хөгжмийн зохиолч Ли Ши Шианы бүтээлүүдийн онцлог нь хятадын уламжлалт болон орчин үеийн хөгжмийн хэв шинжийг агуулахаас гадна Өвөр Монголын олон аймаг, нутаг хошуудын аялгууг өөртөө шингээсэн, тэдгээрийг өрнө дахины төгөлдөр хуурын зохиомжид түшиглэн боловсруулсанаар Өвөр монголчуудын ардын дууны өнгө тембр, хөг намба, фактур, уртын дууны дуулах онцлогийг төгөлдөр хуурт чадамгай илэрхийлсэнд оршино.

Монголын өндөрлөгт үе улиран амьдарч ирсэн монголчууд түүхээсээ “Дуун далай” хэмээх нэрийдэлтэй байжээ. Гэвч одоогийн нийгмийн нисэх мэт түргэн хөгжилтийг даган үндэстний уламжлалт дуу хөгжмийн уламжлах арга маяг нь ч түргэн хувиралтай болж байна. Тал нутгийн аж ахуйн цэцэглэлт, соёл урлагийн шинэчлэлийн дунд төгөлдөр хуур хэмээх “Өрнө дахины хөгжмийн зэмсэг” ч тал нутгийн хүмүүст тийм ойлгогдохгүй сонин содон зүйл биш болж, айл гэрийн хоймрыг эзлэх болсон. Тал нутгийн гэрэлт сувд хэмээгдсэн хотын өндөр сүрлэг барилгад ч гэсэн, эсвэл дэлгэр уудам тал нутгийн өндгөн цагаан гэрт ч гэсэн А.Томпсон, К.Черни мэт алдарт хүмүүсийн зохиолууд сонсогддог болсон. Тиймээс өлгий нутагтаа төрж өссөн тал нутгийн хөгжмийн зохиолч хийж чадна эсвэл заавал хийх гэсэн хоёр үг нь “хөгжим зохиох” болсон байна. Тэрээр төгөлдөр хуур хөгжмийг хүн бүрийн сонирхдог хөгжмийн зэмсэг болгох, тал нутгийн хөгжмийг төгөлдөр хуураар дамжуулан үндэсний бахархал болгох, тал нутагтаа хайртай хүн бүхэнд сэтгэлийн ертөнцийг нээн ойлгуулах чиглэлээр өөрийн уран бүтээлийн үйл ажиллагаадаа эрхлэн явуулдаг юм.

Нөгөөтэйгүүр хөгжмийн зохиолч Ли Ши Шиан дуу хөгжмийн заан сургах ажилтны хувьд өөрийн бүтээн туурвисан бүтээлээрээ дамжуулан хөгжийн зохиомжийн мэргэжлээр суралцагсдад монгол үндэсний хэв шинжийг агуулсан бүтээлийг хэрхэн зохион туурвих арга зүйг заан өгөхийг санаж тус цувралдаа бүтцийн хувьд энгийн болон нийлмэл хэлбэр, бичлэгийн хувьд уламжлалт, сонгодог, орчин үеийн хэв намба бүхий хөгжмийн хэллэг, ухагдахууныг уян хатан байдлаар хэрэглэхийг зорьсон болно. Дээрх бүтээлээр

дамжуулан монгол үндэстний дуу хөгжим ялангуяа ардын дууны өв сангаас хүртээх, уламжлуулах зорилгоор дүрслэн илэрхийлэхийг хичээв.

Жижиг хэлбэрийн дан хөгжмийн бүтээлээс том хэлбэрийн бүтээл болох концерт туурвисан Ли Ши Шиан монгол ардын дуу хөгжмөөс сэдэвлэсэн цуврал аязууд зохиох санаа Урлагийн дээд сургуульд хөгжмийн зохиомжийн багшаар ажиллаж эхлэсэн тэр л үеэс эхэлсэн гэж болно. Тэрбээр эхлээд Өвөр Монголын аймаг хошуудаар явж зохих хэмжээний дууны судлагааг хийж, нэлээд олон дуу цуглуулжээ. Монгол хөгжмийн онцлог, дуурьсал, эгшиглэгээ, цомнол, хөг дэвсгэр, зохиролжуулга зэрэг нь түүнд тийм ч хол биш байсан нь түүний зарим бүтээлээс тодхон хагагдаж байна.

Хөгжмийн зохиолч өөрийн зохиолынхоо эхэнд “Нутгийн зохиолчид” –ын зохион бүтээсэн “Нутгийн бүтээл” нь тал нутагт хайртай хүмүүст үнэн бодитой мөртөө шинэ соргог нутаг орны уур амьсгалыг авчирч өгөх болов уу” хэмээн бичсэн байна. Харин түүний зохиолын талаар зарим хөгжим судлаачид яаж хүлээж авсанаас цухас дурдвал: Миний хайрт шавь Ли Ши Шиан өөрийн бүтээсэн Монгол үндэстний хэв намба бүхий төгөлдөр хуурт зориулсан цуврал бүтээлийн гар бичмэл авч ирэв. Тус цуврал нь дөчин долоон аяыг, төгөлдөр хуураар 10 бүлгийг холбон бүтээсэн байна. Тэр намайг гарчгийг англи хэлээр орчуулан өгч, мөн оршил хэсгийг бичиж өгөхийг хүссэн. Эдгээр хөгжмийн нэрийг орчуулах явцад Дундад улс болон өрнө дахины соёлын зөрөө хийгээд хоёр зүйлийн уламжлалт соёлын адил бусаас үүсэн хэрэглэж байгаа дэвсгэр хөгийг тодорхойлсон түлхүүрийн “тэмдэг” –ийн утгын адил бусыг улам гүн мөртөө бодитойгоор ойлгов. Ялангуяа энд бас нэгэн умардын тал нутгийн соёлын онцгой үнэр амттай асуудал буй. Жишээлбэл: “Овоо”, “Андай” зэрэг үг нь Өвөр Монголын хүмүүсийн хувьд авч хэлбэл шүлгийн ур, сэтгэлий нь оргилуулдаг. Энэхүү соёлыг хүртээгүй хүмүүсийн хувьд авч үзвэл зөвхөн нэг үсэг бичгийн тэмдэг төдий л юм чинь Өрнө дахины хүмүүст юу хэлэх билээ? Иймээс “овоо” хэмээх үгийг авиачлан орчуулгын ард “mongolian caim” хэмээх үгийг дагалдуулан тайлбарласан байна. Үүгээр миний бие ч зохиогчийн тус хөгжмийн түүврийг зохион бүтээсэн уул санааг олж түүний халуун сэтгэл хийгээд хайн сүвэгчлэх зориг санаанд ихээр сэтгэл догдолсон” байна ᠳᠣᠵᠠᠵᠢ ᠳᠡᠭᠡᠳᠡ ᠠᠨᠠᠭᠤ Do Zhao Zhi àè-ñýí ààéià.

Тус төгөлдөр хуурын цуврал бүтээлийг 2 төрөлд хувааж болно: Нэг төрөл нь монгол ардын дууны аялгууг үндэслэж, түүнийг боловсруулан зохион бүтээсэн бүтээл болно. Энэ төрлийн бүтээлийн дотор монгол ардын дууны хэв намба болон санаа ахуйг илрүүлсэн мөртөө бас түүний шүлгийн хэлбэр болон зохирол зүйл, логик шинжийг олж чаджээ. Зохиогчоос энэ талаар хятад үндэстний ардын дуу дахь олон төрлийн хөгийн хэлбэрийг шийдвэрлэх арга (тухайлбал, чин хөг, яа хөг, ен хөг) –ыг толь болгосон мөртөө бас өрнө дахины их, бага хөгийн хэлбэрийн харилцан уусалцах аргыг ч ашигласан байна. Жишээлбэл: Нэгдүгээр ая “Замын хажуу дахь дэгжин бяцхан буга” –д зохиогчоос В үй (5 эгшигт 5 дугаар хөг нь) хөгийн 5 эгшгийн шинжит аккордуудын зүйлийг хэрэглэсэн мөртөө бас яа (5 эгшигт сууринд жи болон гүнг нэмсэн 7 эгшгийн нэг зүйл) хөг дэх жи (5 эгшигт 4 дүгээр хөг) хөгийг ашиглажээ.

Нөгөө нэг төрөл нь даруй зохиогчоос ардын дууг ашиглаагүй бие дааж зохион бүтээсэн явдал болно. Үүний доторхи нэг зүйл нь бүрэн төгөлдөр гол сэдэвт хөгжмийн өгүүлбэр болон түүний хөгжлийн явц дунд зохион бичсэн арга болно. Даруй “уламжлалт” арга мэргэжлийн хэв намба хэмээгдсэн нь зохион бичих арга хэлбэрээр бичсэн хөгжмийн зохиол болно. Жишээлбэл: “Багачуудын наадмын зураг дүрс” дэх эл янзын ая. (Нотын жишээг хавсралтаас харна уу)

Энэ хэсэг хөгжмийн ая нь зохиогчийн өөрөө зохиосон ая болох учраас хөгийн хэлбэр, хөгийн шинжийн эргэлт нь чөлөөтэй олон янзын байж гол сэдвийн хөгжилт нь хөгжмийн зохиолчийн утга санааг агуулжээ. Тухайлбал, “Бөх талбайд орж ирсэн нь” хэмээх ая нь бүтэц, хэмжээгээр их биш боловч В гүн хөг (5 эгшигтийн 1 дүгээр хөг), F жи хөг (5 эгшигтийн 4 дүгээр хөг), G үи хөг (5 эгшигтийн 5 дугаар хөг), C гүн хөг зэргийг хэрэглэж, төгсгөлд нь мөн В гүн хөгт буцсан байна. Зохирол аялгуу хувирахын хамт бас шинэ хөгийн хэлбэр буй болжээ. Нөгөө зүйл нь аялгуу буюу эсвэл өөр маягийн хэлбэрийн бичлэгийн аргыг хэрэглэж, орчин цагийн зохион бичих арга маягаар бичигдсэн хөгжмийн ая болно. Жишээлбэл: “Зөөлөн салхинд үлээгдэх аргалын утаа” гэх аянд зүүн баруун гар нь 2 тавцаар бүтэж бүхий л аялгын хэлбэр нь гуравц дээр байдаг. Зохиогчоос энэ төрлийн хөгжмийн ая дунд монгол үндэстний хэв намба бүхий аялгууг хэрэглэхийн хамт аялгууны төрлөөр хөг аяын бүтцийн элементийг захиран бүхий л цогцот чанартайгаар хөгждөг. Гэхдээ “Үлгэр ярих” хэмээх аянд олонтаа хувирдаг зохиомжийн арга хэрэглэж бүтэц болгосон мөртөө хөгжмийн аяыг хөгжүүлжээ.

Энэхүү оршилд аливаа бүхий л талыг хөндөж чадна гэдэг нь яриангүй байж болшгүй хэрэг. Ярья гэж санагдсан зүйл нь зөвхөн зохиогчийн бүтээх явц дахь аливаа хүсэл хөөцөлдөл болно. Аялгууны хөг, зохирол ая, давхацсан хөг, аяны хэлбэрийн бүтэц аль нь ч гэсэн монгол үндэстний дуу хөгжмийн өвөрмөц онцгой сэтгэлгээний талыг уудлан илрүүлэхэд хүчин зүтгэсэн юм. Үүнд идэвхтэй мөртөө үр бүтээмжтэй эрэл хайгуул хийгджээ. Аливаа нэгэн урлагийн боловсрон хөгжин цэцэглэх нь хэзээд нэг бүлэг хөгжмийн зохиолчдын хүч зоригийн тасралтгүй чармайлтаар аажмаар хөгждөг. Ли Ши Шианы энэ цуврал бүтээл хэвлэгдсэн нь ая зохиох, заан сургах буюу эсвэл хүүхдэд төгөлдөр хуур сургах сурган хүмүүжлийн алинд ч гэсэн гавъяа зүтгэл болох юм.

Өвөр Монголын Их Сургуулийн Урлагийн дээд сургуулийн төгөлдөр хуурын нэгдүгээр дамжаанд 8 этюд, 2 олон хоолойн зохиол, 2 том хэлбэрийн зохиол, 6 пьесыг оюутанд заавал хөгжимдөхийг заасан байдаг. Үүнд:

К.Черни, М.Климент, Ф.Шопены этюдууд, И.С.Бахын болон Д.Шостаковичийн 24 прелюди, фуга зэрэг олон хоолойн зохиолууд, И.Гайдн, В.А.Моцарт, Л.В.Бетховен, С.Прокофьев, Д.Кавалевскийн том хэлбэрийн зохиолууд, Г.Ф.Гендель, В.А. Моцарт, Л.В.Бетховен, Ф.Мендельсон, Ф.Шуберт, Ф.Лист, Ф.Шопен, С.Рахманинов, К.Вебер, К.Дебюсси зэрэг зохиолчдын пьесыг хөгжимдөнө.

Хятадын хөгжмийн зохиолчдоос Ван Лисан, Ван Жинжун, Сан Тун, Хэ Лүдин, Хуан, Хөвэй, Чун Ван Хуа, Лю Жуан нарын төгөлдөр хуурын зохиолууд, харин монгол зохиол гэвэл Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ийн 2,4 дүгээр бүлгийг хөгжимдөхийг тусгасан байдаг.

Хоёрдугаар дамжаанд төгөлдөр хуурын мэргэжлээр сурч буй оюутан 8 этюд, 2 олон хоолойн зохиол, 2 том хэлбэрийн зохиол, 4 пьес хөгжимдөхийг нэр заасан байдаг.

Ф.Шопен, Ф.Лист, С.Рахманиновын этюдууд, И.С.Бахын олон хоолойн зохиолууд, В.А.Моцарт, Ф.Шуберт, А.Григийн том хэлбэрийн зохиолууд, Ф.Шопен, Ф.Лист, И.Брамс, К.Дебюсси, С.Рахманинов, А.Хачатурян нарын пьесүүд, Хятадын хөгжмийн зохиолчдоос Ван Жин Жуа, Жан Зү Шин, Чин Пэй Сюн, Сюн И Чан, Цуэй Ши Гуан, Лиэ Шин Жин, Ван Ли Сэн нарын нэр заасан зохиолууд, монгол зохиол гэвэл Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ийн 6,8 дүгээр бүлгийг хөгжимдөхийг заажээ.

Гуравдугаар дамжаанд оюутан 6 этюд, олон хоолойн болон том хэлбэрийн зохиол тус бүрийг, 4 пьес хөгжимдөхийг заасан байдаг. Үүнд:

Ф.Шопен, Ф.Лист, С.Рахманинов, А.Скрябин, К.Дебюсси нарын этюдууд, И.С.Бахыг олон хоолойн зохиолууд, Л.В.Бетховен, Р.Шуман, Ф.Лист, Ф.Шопен, С.Прокофьевийн том хэлбэрийн зохиолууд, Ф.Лист, Ф.Шопен, Ч.Брамс, С.Рахманинов, А.Скрябин, К.Дебюсси, Р.Шуман, М.Мусоргский нарын пьесүүд, Хятадын зохиолчдоос Жу Зэн Ар, Чин Мин Жи, Дү Мин Син, Ү Зү Чян, Ван Ли Сэн нарын зохиолыг хөгжимдөхөөр заажээ.

Дөрөвдүгээр дамжаанд оюутан Ф.Лист, Ф.Шопен, Ч.Брамс, С.Рахманинов, А.Скрябин, К.Дебюсси нарын этюдууд, И.С. Бахын олон хоолойн зохиол, К.Тауричийн Токката ба фуга, В.А. Моцарт, Л.В.Бетховен, Ф.Лист, Ф.Шопен, Ч.Браме, С.Рахманиновын том хэлбэрийн зохиолууд, Ф.Шопен, В.Лист, Р.Шуман, К.Дебюссийн уран сэтгэмжүүд, Хятадын хөгжмийн зохиолчдоос Ван Жин Жуа, Сан Тун, Жоу Юэйн, Дин Шан Дэ, Ван Ли Сэн нарын бүтээлийг хөгжимддөг байна.

Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн төгөлдөр хуурын ангид монголын хөгжмийн зохиолчдын энэ чиглэлээр бичсэн бүтээлүүд тоглогддоггүй, харин бидний сонгосон Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл”-ийн 2,4,6,8-ыг нэгээс хоёрдугаар дамжаанд заавал хөгжимдүүлдэг байна.

Энд Хорчин нутгийн дуу бүжгийн хөгжмөөс сэдэвлэсэн “Багачуудын наадмын зураг дүрс” гэсэн хоёрдугаар бүлэг, “Тал нутгийн зан үйлийн тухай үзэмж” дөрөвдүгээр бүлэг, “Монголын өндөрлөгийн үзэмжит зургийн агуулга” зургаадугаар бүлэг, “Чин сэтгэлийн дуу-уртын дуу” гэсэн наймдугаар бүлгийг заавал хөгжимдөх сургалтын урын санд тусгажээ. Өөрөөр хэлбэл Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуульд Монгол үндэсний дуу хөгжмийн хэв шинжийг агуулсан ганц зохиол нь бидний судалж буй Ли Ши Шианы “Төгөлдөр хуурын цуврал бүтээл” болно. Гэхдээ тус сургуулийн төгөлдөр хуурын ангийн 3,4 дүгээр дамжаанд монголын хөгжмийн зохиолчдын буюу монгол хөг аялгууг агуулсан ямар ч бүтээлийг хөгжимддөггүй болно.

[1] Асафьев.Б “Хөгжмийн хэлбэр-явц болох нь” ,Изд-во “Музыка “.

[2] Ли Ши Шиан “Монгол үндэстний хэв намба бүхий төгөлдөр хуурт зориулсан цуврал бүтээл “ ,2001,Хөх хот.

Тус эх бичгийг 2010-10-30-д олов.

Зохиогчийн товч танилцуулга: Гэрэлтийн Саруул (1972-) ,эмэгтэй,Монгол үндэстн, Өвөр Монголын Хорчин баруун гарууи дундад хушууны хүн. Өвөр Монголын Их сургуулийн Урлагийн дээд сургуулийн багш,төгөлдөр хуурын хөгжмийн талаар голчлон судлалж буй.